



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 11 сарын 24 өдөр

Дугаар 52

Дархан сум

Орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн
этгээдийн албан тушаалын цалин, хөлсний доод
нийтлэг жишгийг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсгийн 35.1.11, 35.1.12, 35.1.17, 48 дугаар зүйлийн 48.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1, 102 дугаар зүйлийн 102.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн албан тушаалын цалин, хөлсний доод нийтлэг жишгийн хэмжээг хавсралтаар баталсугай.

2. Монгол Улсын Засгийн газрын тогтоолд заасан төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод хэмжээтэй дүйцүүлэн, цалинг хөлсний хэмжээг тогтоон холбогдох хууль тогтоомжийн дагуу бусад нэмэгдэл, урамшууллыг тооцож олгохыг орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлагууд, аймаг, сумын Засаг дарга нарт даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хангуулж, гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Б.Азжаргал)-д үүрэг болгосугай.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ



М.ЖАРГАЛСАЙХАН

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2023 оны 01 дугаар сарын 29-ны өдрийн
02 дугаар тогтоолын хавсралт



ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИН, ХӨЛСНИЙ ДООД НИЙТЛЭГ ЖИШГИЙН ХЭМЖЭЭ

Албан тушаал			Цалин хөлс (МУЗГ-ын баталсан төрийн үйлчилгээний албан хаагчийн цалин хөлстэй жиших)
Удирдах	Гүйцэтгэх	Туслах	
1.Захирал 2.Дарга			ТУ-9 жиших
1.Ерөнхий инженер	1.Эдийн засагч 2.Ерөнхий нягтлан бодогч 3.Алба, нэгжийн дарга 4.Ахлах инженер		ТУ-8 жиших
	1.Маркетингийн менежер 2.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн инженер, ажилтан 3.Инженер 4.Мэргэжилтэн 5.Хүний нөөцийн ажилтан 6.Зоххион байгуулагч 7.Агрономич 8.Тооцооны нягтлан бодогч		ТУ-7 жиших
	1.Нийгмийн ажилтан 2.Тооцооны ажилтан		ТУ-6 жиших
	1.Механик 2.Техникч 3.Агрономич 4.Эмч 5.Архив-бичиг хэрэг		ТУ-5 жиших

		1. Нярав 2. Орлого бүрдүүлэгч 3. Тусгай зориулалтын жолооч 4. Диспетчер	ТҮ-4 жиших
		1. Жолооч 2. Цахилгаанчин 3. Гагнуурчин 4. Сантехникч 5. Тогооч 6. Камерын хяналтын ажилтан 7. Жолооч-Оператор 8. Цэцэрлэгч 9. Слесарь	ТҮ-3 жиших
	1. Зам талбайн үйлчлэгч 2. Мужаан 3. Байцаагч 4. Пүүлэгч 5. Бохирын оператор 6. Уурын зуухны галч		ТҮ-2 жиших
		1. Үйлчлэгч 2. Арчлалт хамгаалалтын ажилчин 3. Ачигч 4. Харуул 5. Сахиул 6. Гал тогооны туслагч	ТҮ-1 жиших